

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА САКЕЙН ХАВАЛЫН  
ЕРӨНХИЙ САЙДТАЙ БАЙГУУЛСАН “БАТЛАМЖ”-ААР  
ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2009.12.30

<b>Д/д</b>	<b>Заалт</b>	<b>Хувь</b>
1	Аймгийн иргэдийн нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлж Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.	95%
2	Төр, засгийн төлөөлөгчийн хувьд төрийн хууль ёсыг чандлан сахиж Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллана.	100%
3	Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдлээс ангид байлган, иргэдэд нээлттэй, ил тод, шударгаар шуурхай үйлчилнэ.	100%
4	Аймгийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг сайжруулж, төсвийн сахилгыг чанд сахиж, авлига, хээл хахуулийг цээрлэн ажиллана.	100%
5	Аймгийн эдийн засгийн бодит өсөлтийг хангахын зэрэгцээ, соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн салбарын жигд хөгжлийг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэн ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулж ажиллана.	91%
6	Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангаж, гэмт хэрэг, архидан согтуурах явдалтай тууштай тэмцэж, сахилга хариуцлагыг өндөржүүлж ажиллана.	95%
7	Засгийн газрын шийдвэр, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, удирдах бусад албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, үр дүнг тогтмол тайлагнаж, дэмжлэг туслалцаа авч ажиллана.	100%
8	Албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь шаардлага хангахгүй байгаа болон төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, хууль зөрчиж албан тушаалаа хувийн зорилгодоо ашигласан, авлига, хээл хахуульд холбогдсон, ёс суртахууны доголдол гаргасан, архидан согтуурсан тохиолдолд улс төрийн хариуцлага хүлээнэ. Хариуцлага алдаж албан тушаалаасаа чөлөөлөгдөх асуудал нь улс төрийн намын хаацайллыг эрэлхийлэх шалтгаан болохгүй.	100%
9	Энэхүү батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг жил тутам Засгийн газарт тайлагнана.	100%
	<b>ДҮН</b>	<b>98%</b>

**Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн хэрэгжилтийн явцын талаар;**

**1. Засаг төрийн төлөөлөгчийн хувьд Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг өөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл гэж үзэж хэрэгжүүлж ажиллана.**

Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэслэн Баян-Өлгий аймгийг 2010-2021 онд хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн. Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн эхний жилийн буюу 2009 хэрэгжилт 90,4%-тай байна.

**2. Батламжаар хүлээсэн үүргийг биелүүлэхдээ хууль ёсыг чандлан сахих зарчим баримтлан Монгол улсын Үндсэн хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллана.**

Ерөнхий сайдтай байгуулсан батламжийн гэрээг үндэслэн нийт сумдын Засаг дарга нартай батламжийн болон санхүүжилт, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, хэрэгжүүлэгч агентлагийн дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэх, төрийн хууль ёсыг сахин биелүүлэх гэрээ байгуулан үр дүнг тооцон ажиллаж байна.

**3. Нутгийн захиргааны байгууллагыг мэргэжлийн ур чадвартай, дадлага туршлагатай, үнэнч шударга, хариуцлагатай, ёс суртхууны доголдолгүй, өндөр боловсролтой төрийн захиргааны мэргэшсэн албан хаагчдаар бэхжүүлэн цомхон чадварлаг аппарат бүрдүүлнэ.**

Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдлээс ангид, иргэдэд нээлттэй, ил тод, шударга байлгахад чиглэсэн “Нээлттэй хаалганы өдөрлөг”, төрийн үйлчилгээний байгууллагуудын тайланг иргэдээр хэлэлцүүлдэг, хяналт-шинжилгээ, үнэлгээ, санхүүгийн аудит хийлгэж үр дүнг нийтэд мэдээлдэг зэрэг цогц арга хэмжээ авч байна.

**4. Аймгийн төсвийн бүрдэлт, зарцуулалтыг сайжруулах, хуваарилалтыг оновчтой болгох, төсөвт зардлыг хэмнэх, төсвийн орлого нь зарлагаа нөхөх байх зарчмыг баримтлан, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллана.**

2009 онд улсын төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөг 19 хувиар буюу 100,0 орчим сая төгрөгөөр орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 25 хувиар буюу 500 орчим сая төгрөгөөр давуулан биелүүлсэн. Ногооннуур, Булганаас бусад бүх сумдыг төрийн сангийн нэгдсэн сүлжээнд холбосон.

**5. Аймгийн эдийн засгийн өсөлтийг хангахын зэрэгцээ нийгэм, соёл, боловсрол, эрүүл мэндийн салбарын зорилтуудыг шийдвэрлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэн, ажилгүйдэл, ядуурлын түвшинг бодитой бууруулж, нийгмийн эмзэг хэсэгт үзүүлэх үйлчилгээг эрс сайжруулж, цалин тэтгэвэрт тэтгэмжийг цагт нь олгож байна.**

5. 2009 онд аймгийн мал аж ахуйн салбараас бусад эдийн засаг, нийгмийн бүх салбарт ахиц гарсан. /судалгааг хавсаргав/

**6.Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангаж, архидан согтуурах явдалтай тууштай тэмцэж тодорхой ахиц гаргаж, үр дүнд хүргэж ажиллана.**

6. 2009 онд аймгийн хэмжээндэх нутгийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилж, түүнд хариуцлага сахилга батыг сайжруулах асуудлыг тодорхой тусгаж, хүлээлгэх хариуцлагыг чангатгасан. 2009 онд аймгийн хэмжээнд гэмт хэргийн тоо өнгөрсөн оныхоос 30%-иар буурсан.

**7.Засгийн газрын шийдвэр болон Монгол улсын Ерөнхий сайдаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай хэрэгжүүлж, тэдгээрийн явц, үр дүнг тогтмол мэдээлж байна.**

7. Төр, Засгийн удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг бүрэн биелүүлж, байнгын дэмжлэг тусалцаа авч байгаа.

**8.Монгол улсын Засгийн газар, Ерөнхий сайдын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, төсвийн хөрөнгийг буруу зарцуулсан, албан тушаалаа амин хувийн зорилгодоо ашигласан, ёс суртхууны доголдол гаргасан, албан өрөөндөө болон ажил үүрэг гүйцэтгэж байхдаа архидан согтуурсан зэрэг тохиолдолд өөрийн албан тушаалаас шууд татгалзана. Эсвэл Монгол улсын Ерөнхий сайд Засаг даргыг албан тушаалаас нь чөлөөлнө.**

8. Батламжаар хүлээсэн үүргийнхээ дагуу өөрөө аливаа хууль бус үйлдлээс ангид байхын зэрэгцээ ажилдаа хариуцлагагүй хандсан удирдах ажилтан 6 хүнд хариуцлага тооцсон.

**9. Энэхүү батламжаар хүлээсэн үүргийн биелэлтийг хагас ба бүтэн жил тутам Монгол улсын Ерөнхий сайдад тайлагнаж байна.**

Батламжийн биелэлтийг хагас, бүтэн жил тутам заалт бүрээр тооцож хүргүүлэн ажилласан болно.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ